НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,
1 дүгээр хороо,Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160 0035
Утас (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.05.13 № 03/2742

танай ________ -ны № ________ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамж (Улаанбаатар хот)” НЗДТГ/202401022009 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой “Топика” ХХК-иас 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

1.“Теле камерын хяналтын дэд төв” байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, систем, програм хангамж (Улаанбаатар хот) төсөл арга хэмжээний ажлын даалгаврын 2.1.2-т Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад одоо ашиглагдаж байгаа теле хяналтын системийг “Теле хяналтын камерын дэд төв”-тэй холбоно гэж заасан байна. Энэхүү “Теле хяналтын камерын дэд төв”-үүдийн байршлын мэдээллийг нарийвчлан ирүүлнэ үү?

Хариулт: Нийслэлийн 9 дүүргийн нутгийн захиргааны байгууллагын дэргэд байгуулах “Теле камерын хяналтын дэд төв”-үүдийн байршлыг “Google Earth Pro” программ ашиглаж уртраг, өргөргийн тодорхойлсон.

| № | Дүүрэг | Байршлын нэр | Уртраг, Өргөрөг |
|---|---|---|---|
| 1. | Баянгол дүүрэг | Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын байр | 47°54'38.36"N 106°52'42.18"E |
| 2. | Баянзүрх дүүрэг | Баянзүрх нэг зүрх төвийн байр | 47°54'45.56"N 106°58'57.36"E |
| 3. | Сонгинохайрхан дүүрэг | СХД-ийн 16 дугаар хорооны цогцолбор байр | 47°54'56.12"N 106°50'12.65"E |
| 4. | Сүхбаатар дүүрэг | СБД-ийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт | 47°57'15.22"N 106°55'11.08"E |
| 5. | Хан-Уул дүүрэг | Хан-Уул дүүргийн 16 дугаар хороонд байгуулах | 47°51'29.87"N 106°45'44.31"E |
| 6. | Чингэлтэй дүүрэг | Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний төвийн байр | 47°57'52.09"N 106°52'11.24"E |
| 7. | Багануур дүүрэг | Багануур дүүргийн Засаг даргын тамгын газрын байр | 47°46'51.17"N 108°21'58.50"E |
| 8. | Багахангай дүүрэг | Багахангай дүүргийн 2 дугаар хорооны байр | 47°21'9.58"N 107°29'27.54"E |
| 9. | Налайх дүүрэг | Налайх дүүргийн Шуурхай удирдлага, хяналт мэдээллийн төвийн байр | 47°46'14.61"N 107°15'13.47"E |

2.Цагдаагийн байгууллага болон Теле хяналтын камерын дэд төв хооронд шилэн кабелиар холбох зардлыг тооцоолохдоо хэдэн шөрмөсийн шилэн кабелиар холбоно гэж тооцоолох вэ?

1110202447

Хариулт: Дүүргийн цагдаагийн хэлтсүүдийн байранд теле камер, хяналтын системийн тоног төхөөрөмжүүд байрлаж байгаа бөгөөд шаардлагатай бичлэгийн төхөөрөмж, сүлжээний салаалагч төхөөрөмжүүдийг шилжүүлнэ. Цагдаагийн хэлтсийн байранд 2-4 ширхэг 42U-ийг зогсуур байгаа. Мөн одоо гудамж, зам, талбайд байрлуулсан теле камерын шилэн кабелын (12-96 шөрмөс) холболтыг шилжүүлэх ажил хийгдэнэ.

3.2.1.13-т "Теле камерын хяналтын дэд төв"-ийн цахилгааны эх үүсвэр нь 2-оос доошгүй найдвартай холболтыг хийсэн байхаар зохион байгуулж Улаанбаатар цахилгаан түгээх үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авсан байна гэж заасан байна."Телехяналтын камерын дэд төв"-ийг цахилгааны эх үүсвэрт холбох зайг хэдэн метр гэж тооцоолох вэ?

Хариулт: Нутгийн захиргааны байгууллагын дэргэд байгуулах "Теле камерын хяналтын дэд төв"-ийн байрын байршлын судалгааг гарган хүргүүлж байгаа тул дээрх мэдээллийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д хүргүүлж цахилгааны эх үүсвэрийн зайг тодорхойлуулах боломжтой.

4.Ажлын даалгаврын хүснэгтийн 27-д Засварын ажил Дэд хяналтын төвийн хяналтын өрөө, серверийн өрөө, хурлын заал, алба хаагчдын оффисын өрөөний засвар гэж заасан байна. Засварын ажил хийх байруудын метр квадратын хэмжээг ирүүлнэ үү.

Хариулт: Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын дэргэд байгуулах "Теле камерын хяналтын дэд төв"-ийн байрны зохион байгуулалт (одоо байгаа), байршил, барилгын хийц нь харилцан адилгүй бөгөөд ханан дэлгэц бүхий хяналтын өрөө, тоног төхөөрөмж байрлуулах серверийн өрөөг ижил загвараар бүрэн засварлана. Ханан дэлгэц бүхий хяналтын өрөөний хэмжээ ойролцоогоор 10х13 метр, тоног төхөөрөмж байрлуулах серверийн өрөө нь 6х6 метрийн хэмжээтэй байна. Хана нураах, өрөх, хаалга суурилуулах ажил гарна. Шаардлагатай бол бусад өрөөнүүдэд өнгө засвар хийж болно. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн байр тодорхой болсон тул шаардлагатай бол газар дээр нь очиж үзэх боломжтой болно.

5.Ажлын даалгаврын хүснэгтийн 28-д Цагдаагийн хэлтсээс дэд төв рүү тоног төхөөрөмж шилжүүлэх ажил тусгагдсан байна. Үүнд шилжүүлэх тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг ирүүлнэ үү?

Хариулт: Дүүргийн цагдаагийн хэлтсүүдийн байранд теле камер, хяналтын системийн тоног төхөөрөмжүүд байрлаж байгаа бөгөөд шаардлагатай бичлэгийн төхөөрөмж, сүлжээний салаалагч төхөөрөмжүүдийг шилжүүлнэ. Шилжүүлэх төхөөрөмжийн тоо хэмжээ харилцан адилгүй тул мэдээллийг газар дээр нь очиж үзэх боломжтой болно.

ДАРГА Л.ХОСБАЯР